


УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН
ТӨВӨӨС НИЙСЛЭЛИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГУУДЫН АЛБАН
ХААГЧДЫН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН МЭДЭЭ

2023 оны 05 дугаар сарын 01

Улаанбаатар хот


Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд уг судалгааг явуулсан ба Төвийн үндсэн үйл ажиллагааг сайжруулах, “Харьцааны заавар”-ын хэрэгжилт, Улаанбаатар хотын гэрэлтүүлгийн байгууллагууд болон Төв хоорондын ажлын уялдаа холбоо ямар түвшинд байгааг үнэлэх зорилгоор /”Холбоо трейд” ХХК, “Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК, “Төгс гэрэлтүүлэг” ХХК, “Филипс гэрэлтүүлэг” ХХК, “Новельнэтворк” ХХК, “Энержи комплекс” ХХК, “Ар хөвчийн эрчим” ХХК, “Нийслэл түгээх сүлжээ” ХХК, “Грийн электрик инженеринг” ХХК, “Смарт контрол” ХХК, “Би Эм Жи Эл” ХХК, “Спейшл тим ап” ХХК, “Их хотын гэрэл” ХХК, “Цацрах хангай” ХХК, “Соёндрийм” ХХК, “Ховд бат арвижих” ХХК/ нийт 16 байгууллагыг хамруулан 2023 оны 04 дүгээр сарын 19-нөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн ажиллалаа. Судалгааг нийт 5 асуултын дагуу явуулсан бөгөөд 89 албан хаагч хамрагдсан. Үүнд:

Асуулт 1: Та манай Төвтэй ямар чиглэлээр илүү холбогдож ажилладаг вэ?




Нийт 89 албан хаагч дээрх асуулгад хамрагдсан ба үүнээс 42.69% нь Иргэдийн гомдол мэдээллийн мөрөөр, 47.20% нь нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн байгууламжийн асуудлаар, 8.98% нь зохицуулалт хийлгэх зорилгоор, 1.13% нь бусад чиглэлээр гэж хариулсан байна.

Асуулт 2: Төвийн Диспетчер инженерүүд нь “Харьцааны заавар”-ын дагуу ажил үүргээ гүйцэтгэж байгаа эсэх?



Судалгаанд нийт 89 албан хаагч хамрагдсан ба үүнээс 96% нь Сайн, 4% нь Дунд гэсэн хариулт өгсөн байна. Хангалтгүй гэсэн хариулт ирүүлээгүй байна.

Асуулт 3: Ажил үйлчилгээтэй холбоотой танай байгууллагад тулгамдаж буй асуудалд Төвийн Ахлах болон диспетчер инженерүүд нь оновчтой арга хэмжээ авч, шуурхай зохицуулалт хийж байгаа эсэх?



Нийт 89 албан хаагч асуулгыг бөглөснөөс 89% нь Сайн, 11% нь Дунд гэж хариулжээ. Хангалтгүй гэсэн хариулт ирүүлээгүй байна.

Асуулт 4: Төвөөс тавьж байгаа гомдол мэдээллийг шийдвэрлэхэд хүндрэлтэй, тулгамдсан ямар асуудлууд хамгийн их гардаг вэ?

- Гэрэлтүүлгийн эзэмшлийн зааг ялгааг гаргах
- Харьяаллын бус дуудлага андуурч шалгуулах
- Орон сууцны хотхон дундах засвар хийхэд хүндрэлтэй техник оруулах боломжгүй
- УБЦТС болон холбооны шонг андуурч шалгуулах

Асуулт 5: Хот, нийтийн үйлчилгээний тасралтгүй, хэвийн ажиллагааг хангуулахад байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог улам сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх, зохицуулалт хийх шаардлагатай асуудлын талаар саналаа бичнэ үү?

- Телеграммаар мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах
- Авто замын нэгдүгээр эгнээнд түр зогсох боломжгүй байдал
- Шилэн кабелийг нэгдсэн байдлаар цэгцлэх
- Зохион байгуулалт уялдаа холбоог сайжруулах
- Баталгаат хугацаа дуусаагүй гэрэлтүүлгийн захиалагчийн хяналтыг сайжруулах
- СӨХ-үүдтэй хамтарч уялдаа холбоог сайжруулах

Дүгнэлт:

Санал асуулгаас харахад гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан байгууллагуудын инженер техникийн ажилтан албан хаагчид нь Төвийн Ахлах болон диспетчер инженерүүдтэй тогтмол холбогдож байгууллага хоорондын “Харьцааны заавар”-ын дагуу мэдээ мэдээлэл авч (сайн буюу 96%), шуурхай зохицуулалт (сайн буюу 89%) хийж ажилладаг болохыг илэрхийлж байна.

Гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан байгууллагуудаас 4, 5 дугаар санал асуулгад гэрэлтүүлгийн эзэмшлийн зааг ялгааг гаргах, цахилгааны болон холбооны шонгийн мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч тодорхой болгох, харьяаллын дагуу гэрэлтүүлгийн гомдол мэдээллийг хүлээн авч шилжүүлэх, Сууц өмчлөгчдийн холбоодын хамтын ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах талаар тус тус санал ирүүлснийг Төвийн зүгээс үндсэн үйл ажиллагаандаа тусган, Диспетчер

инженерүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлж “Тулга систем”-ийн хяналтыг сайжруулж, засвар үйлчилгээний мэдээллийг telegram программаар шуурхай түгээж, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.